**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Цөм сүргийн үржлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ГСА-2024/05/НА-СТА-ОНА**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2024 он | Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179<br>Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Ахлах аудитор:Б.Анхтуяа<br>Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.03.15 № 47
танай ____________-ны № ____________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.БАТБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Цөм сүргийн үржлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говьсүмбэр аймгийн Цөм сүргийн үржлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд тооллого, тооцоо бодолт хийгээгүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.2, 12.2.6, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтууд, Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал: Хөрөнгө 5.11 "Байгууллага нь нөөцийг хянадаг байх ёстой", 5.12 "Нөөцийг одоо хянаж буй эсэхээ тогтоохдоо, байгууллага нь хяналтын дараах үзүүлэлтүүд оршин байгаа эсэхийг үнэлнэ", Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

0008020124

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээллийг ирүүлээгүй болно.

**Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **359,954,264.04** | **337,655,599.49** |
| **33** | **АВЛАГА** | **9,987,774.04** | **12,851,382.83** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,595,000.00 | 1,595,000.00 |
| **33500** | **Бусад авлага** | **8,392,774.04** | **11,256,382.83** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 8,392,774.04 | 11,256,382.83 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **349,966,490.00** | **324,804,216.66** |
| **35100** | **Түүхий эд материал** | **38,807,200.00** | **49,723,200.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 38,723,200.00 | 49,331,200.00 |
| 35130 | Эм боох материал | 84,000.00 | 392,000.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **15,749,290.00** | **13,764,350.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 103,000.00 | 144,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,695,300.00 | 8,590,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,950,990.00 | 5,029,550.00 |
| 35600 | Мал амьтад | 295,410,000.00 | 261,316,666.66 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **68,028,096.88** | **59,350,561.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **68,028,096.88** | **59,350,561.03** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **66,003,096.88** | **57,325,561.03** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 36,115,613.00 | 36,115,613.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -8,606,905.20 | -9,623,882.16 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 66,280,000.00 | 66,280,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -32,632,000.34 | -38,277,333.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 19,237,400.00 | 19,237,400.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17,576,520.46 | -18,774,816.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,048,000.00 | 11,618,400.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,862,490.12 | -9,249,819.09 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **2,025,000.00** | **2,025,000.00** |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -880,000.00 | -880,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,025,000.00 | 2,025,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **427,982,360.92** | **397,006,160.52** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,669,889.32** | **8,495,287.86** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **5,669,889.32** | **8,495,287.86** |
| **41300** | **Өглөг** | **5,669,889.32** | **8,495,287.86** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 560,210.46 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,008,378.86 | 7,695,753.86 |
| **41360** | **Бусад өглөг** | **101,300.00** | **799,534.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 101,300.00 | 799,534.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **422,312,471.60** | **388,510,872.66** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **422,312,471.60** | **388,510,872.66** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 136,284,000.00 | 136,284,000.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 136,284,000.00 | 136,284,000.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **286,028,471.60** | **252,226,872.66** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 317,121,476.82 | 287,734,816.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -31,093,005.22 | -35,507,944.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **427,982,360.92** | **397,006,160.52** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **173,884,725.00** | **175,145,318.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **55,940,325.00** | **25,099,618.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **55,940,325.00** | **25,099,618.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **8,455,325.00** | **8,224,618.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,455,325.00 | 8,224,618.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 47,485,000.00 | 16,875,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **117,944,400.00** | **150,045,700.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **117,944,400.00** | **150,045,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 117,944,400.00 | 150,045,700.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **186,777,728.02** | **210,653,262.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **186,777,728.02** | **210,653,262.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **184,288,878.02** | **208,103,262.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **78,295,490.00** | **97,431,760.00** |
| 210101 | Үндсэн цалин | 41,473,535.00 | 55,147,391.00 |
| 210102 | Нэмэгдэл | 350,000.00 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,810,000.00 | 762,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 34,661,955.00 | 41,522,369.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,865,937.00** | **12,208,957.66** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,650,997.00 | 8,281,700.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 782,471.00 | 974,316.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,408,445.00 | 1,582,684.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 93,094.00 | 120,567.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 930,930.00 | 1,249,688.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,051,117.44** | **5,632,510.24** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 152,485.44 | 204,426.24 |
| 210302 | Түлш, халаалт | 4,867,940.00 | 4,704,590.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 30,692.00 | 723,494.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,155,840.00** | **40,741,016.67** |
| 210401 | Бичиг хэрэг | 167,300.00 | 393,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,170,000.00 | 10,232,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 529,540.00 | 517,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 69,000.00 | 130,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 17,220,000.00 | 29,406,666.67 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **200,000.00** | **1,223,500.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 200,000.00 | 1,223,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **1,420,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 1,420,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,673,530.00** | **3,103,300.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,356,730.00 | 2,478,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 109,800.00 | 109,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109,500.00 | 44,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 61,500.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 286,000.00 | 438,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **63,046,963.58** | **46,342,217.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,921,349.46 | 37,664,681.67 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,125,614.12 | 8,677,535.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,488,850.00** | **2,550,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,461,500.00** | **2,550,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,461,500.00 | 2,550,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,027,350.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,027,350.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-12,893,003.02** | **-35,507,944.09** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **18,200,002.20** | **0.00** |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 18,200,002.20 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-31,093,005.22** | **-35,507,944.09** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **127,769,725.00** | **158,270,318.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,825,325.00** | **8,224,618.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **9,825,325.00** | **8,224,618.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **9,825,325.00** | **8,224,618.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 9,825,325.00 | 8,224,618.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **117,944,400.00** | **150,045,700.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **117,944,400.00** | **150,045,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 117,944,400.00 | 150,045,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **127,769,725.00** | **158,270,318.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **127,769,725.00** | **158,270,318.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **125,342,375.00** | **155,270,318.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **77,400,651.43** | **98,558,148.67** |
| 210101 | Үндсэн цалин | 37,753,656.43 | 45,887,144.41 |
| 210102 | Нэмэгдэл | 9,003,171.00 | 7,360,968.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,766,000.00 | 2,430,847.26 |
| 210104 | Урамшуулал | 966,756.00 | 0.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 27,911,068.00 | 42,879,189.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **9,800,401.99** | **11,875,509.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,585,175.67 | 8,257,308.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 781,000.74 | 976,225.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,405,801.36 | 1,257,445.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 93,493.10 | 214,213.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 934,931.12 | 1,170,315.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,051,117.44** | **5,632,510.24** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 152,485.44 | 204,426.24 |
| 210302 | Түлш, халаалт | 4,659,440.00 | 4,704,590.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 239,192.00 | 723,494.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,166,394.14** | **11,529,450.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 300,000.00 | 500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,068,354.14 | 10,232,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 486,640.00 | 517,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 311,400.00 | 219,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **876,600.00** | **1,878,400.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 876,600.00 | 1,878,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,335,180.00** | **4,293,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 850,000.00 | 853,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,485,180.00 | 3,440,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **1,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,712,030.00** | **3,502,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,356,730.00 | 3,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 139,800.00 | 109,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,500.00 | 56,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 336,000.00 | 304,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **17,000,000.00** | **17,000,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,000,000.00 | 17,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,427,350.00** | **3,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,400,000.00** | **3,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 3,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,027,350.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,027,350.00 | 0.00 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **134,259,000.00** | **0.00** | **316,695,508.89** | **450,954,508.89** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **425,967.93** | **425,967.93** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **134,259,000.00** | **0.00** | **317,121,476.82** | **451,380,476.82** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **2,025,000.00** | **0.00** | **0.00** | **2,025,000.00** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **7** | **Өмчид гарсан өөрчилөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-31,093,005.22** | **-31,093,005.22** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **136,284,000.00** | **0.00** | **286,028,471.60** | **422,312,471.60** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **136,284,000.00** | **0.00** | **286,028,471.60** | **422,312,471.60** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,706,345.15 | 1,706,345.15 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **136,284,000.00** | **0.00** | **287,734,816.75** | **424,018,816.75** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -35,507,944.09 | -35,507,944.09 |
| **20** | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **136,284,000.00** | **0.00** | **252,226,872.66** | **388,510,872.66** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **170,045,700.00** | **158,270,318.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **170,045,700.00** | **158,270,318.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **167,045,700.00** | **155,270,318.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **102,752,200.00** | **98,558,148.67** |
| 210101 | Үндсэн цалин | 52,955,400.00 | 45,887,144.41 |
| 210102 | Нэмэгдэл | 6,758,900.00 | 7,360,968.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,995,800.00 | 2,430,847.26 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 41,042,100.00 | 42,879,189.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,641,600.00** | **11,875,509.09** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,000,800.00 | 8,257,308.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 909,600.00 | 976,225.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 728,400.00 | 1,257,445.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 183,600.00 | 214,213.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,819,200.00 | 1,170,315.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,174,400.00** | **5,632,510.24** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 500,000.00 | 204,426.24 |
| 210302 | Түлш, халаалт | 8,174,400.00 | 4,704,590.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 723,494.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,677,100.00** | **11,529,450.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 500,000.00 | 500,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,232,300.00 | 10,232,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600,000.00 | 517,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 284,800.00 | 219,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,878,400.00** | **1,878,400.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,878,400.00 | 1,878,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,293,500.00** | **4,293,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 853,000.00 | 853,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,440,500.00 | 3,440,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,628,500.00** | **3,502,800.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 705,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 434,200.00 | 109,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 56,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 85,300.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 304,000.00 | 304,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **17,000,000.00** | **17,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,000,000.00 | 17,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,000,000.00** | **3,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,000,000.00** | **3,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **170,045,700.00** | **158,270,318.00** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **150,045,700.00** | **150,045,700.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 150,045,700.00 | 150,045,700.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **20,000,000.00** | **8,224,618.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000,000.00 | 8,224,618.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **4.00** | **4.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 3.00 | 3.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.00 | 0.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 0.00 | 0.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

**Завсрын аудитаар:**

Тус байгууллагад 2023 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 8 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 8,608.6 мянган төгрөгийн 6 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 1,340.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 7,268.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулаагүй тул дараагийн шатны арга хэмжээг авахаар шийдвэрлэсэн.

**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 3,154.9 мянган төгрөгийн 9 шийдвэр, 1,2 дугаар улирлын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг тус тус мэдээлээгүй, нийт 84,355.6 мянган төгрөгийн орлогын 10, 5,744.6 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нийт 93,255.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.3.3, 6.4.5, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.5, 2.2.1.13, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.2, 3.2.10, 3.2.11 дэх заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Аудитаар илэрсэн зөрчлийг нөхөн мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2009 оны А/96 дугаар захирамжаар өвөлжөөний зориулалтаар олгосон /700 м2/ газар эзэмших эрхийг үнэлж бүртгээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4.2, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дахь заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Өвөлжөөний зориулалтаар олгосон газар эзэмших эрхийг холбогдох байгууллагаар үнэлүүлж, бүртгэх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 834.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 834.9 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

***Залруулсан алдаа:***

1. ХХОАТ-т үүссэн авлагыг өмнөх үеийн үр дүн рүү хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй

***Залруулаагүй алдаа:***

Байхгүй

Аудитаар нийт 8,109.0 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 430.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7,679.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

**Төлбөрийн акт**

1. Мал эмнэлэг үржлийн албаны 100 жилийн ойн баярыг тохиолдуулан мал амьтад данснаас 10 толгой малыг /430.0 мянга/ албан хаагчдад шагнал хэлбэрээр хандивлаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зардалд зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.3 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

**Албан шаардлага**

1. Гэрээт малчдад хууль тогтоомжид заагдаагүй нэмэгдэл олгосон, тушаал шийдвэргүй цалингийн зардлаас ажил гүйцэтгэсний хөлс нийт 7,679.0 мянган төгрөгийг олгож ТАЦС-д цалингийн зөрүү хэсэгт тооцоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.1.3, 108 дугаар зүйлийн 108.1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Гэрээт малчдад хөдөлмөрийн гэрээнд заасан цалин хөлсний хэмжээгээр цалин, нэмэгдлийг олгох, батлагдсан цалингийн зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2. Жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй, тооцоо бодсон акт байхгүй, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 12.2.6, 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.6 дахь

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалтуудыг зөрчсөн, Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал: Хөрөнгө 5.11 "Байгууллага нь нөөцийг хянадаг байх ёстой", 5.12-т "Нөөцийг одоо хянаж буй эсэхээ тогтоохдоо, байгууллага нь хяналтын дараах үзүүлэлтүүд оршин байгаа эсэхийг үнэлнэ", Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хөрөнгийн тооллогыг хууль, тогтоомжид заасны дагуу хийх, баримтжуулах, баталгаажуулах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

**Зөвлөмж**

1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн боловч эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 17 нэр төрлийн 17 ширхэг 18,631.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх заалтуудыг зөрчсөн, Үндсэн хөрөнгө УСНББОУС-17-н (67 "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх б а хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт ба алдааны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооны өөрчлөлт байдлар тайлагнана", 82б "Хөрөнгийн ашиглалт эсвэл данснаас хасалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи хүлээгдэхээргүй болсон", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Ашиглалтын хугацаа дууссан 17 нэр төрлийн 17 ширхэг 18,631.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах болон цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж данс бүртгэлд тусгах

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цөм сүргийн үржлийн төв | 4 | 2.2 | 1 | 0.8 | 3 | 1.3 | 4 | 2.2 | | | | |
| **Дүн** | **4** | **2.2** | **1** | **0.8** | **3** | **1.3** | **4** | **2.2** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цөм сүргийн үржлийн төв | 4 | 8.1 | 1 | 0.4 | 1 | 7.7 | 1 | 0.0 | | | | |
| **Дүн** | **4** | **8.1** | **1** | **0.4** | **1** | **7.7** | **1** | **0.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цөм сүргийн үржлийн төв | 1 | 93.3 | | | 1 | 93.3 | | |
| **Дүн** | **1** | **93.3** | | | **1** | **93.3** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цөм сүргийн үржлийн төв | 2 | 5.0 | | | 1 | 5.0 | 1 | 0.0 |
| **Дүн** | **2** | **5.0** | | | **1** | **5.0** | **1** | **0.0** |
| **Нийт дүн** | **3** | **98.3** | | | **2** | **98.3** | **1** | 0.0 |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| | | Аудитад | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | |

| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | | | | | 1 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | | | | | **1** | | |